



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2023/119/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.selenge@audit.gov.mn

Сүхбаатар сум
2023 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа

Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Батмөнх

Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn

Аудитор: Б.Ундаръяа

Утас: 70376994 Цахим хаяг: dalaivandarkhan@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
БШУГ	Боловсрол шинжлэх ухааны газар
ХНХС	Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд
ЗГ	Засгийн газар
ОУБ	Олон улсын байгууллага

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
3.Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.1.Байгууллага түүний үйл ажиллагаа.....	13
3.2. Байгууллагын гадаад дотоод орчин.....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	14
3.4. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд ..	14
3.5. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	16
4.Аудитын тайлан	17
4.1 Ерөнхий зүйл.....	17
4.2 Материаллаг байдал.....	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	20
5. Аудитын илрүүлэлт	21
5.1 Акт.....	21
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	22



Г ХҮДЭР СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Д.МӨНХНАРАН ТАНАА

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2023-02-26 № САА-2023/119-НА-САА-ТЧЗ
танай _____-ны № _____-г

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хүдэр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Хүдэр сумын ерөнхий боловсролын сургууль нь үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсөн санхүүжилтийг бүрэн төвлөрүүлж, төсвийн гүйцэтгэл 90.5 хувьтай тайлагнагдсан байна.

Цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардлыг 105,454.3 мянган төгрөгөөр, төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшууллын зардал 16,108.8 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 8,344.1 мянган төгрөгөөр тус тус хэмнэснээс голлон шалтгаалж, нийт батлагдсан төсөв 9.5 хувиар хэмнэгдсэн байна.

018020241

Аудитын гол асуудал

Хүдэр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны нийт төсвийн зарцуулалт, ажил гүйлгээний 72.2 хувийг цалин хөлс, нэмэгдэл урамшил, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал, 11.4 хувийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардал эзэлж байна.

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/ төгрөгөөр /			
Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	0.00	217,353,226.50
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.00	136,729,918.35
31100	Кассанд байгаа бэлэн мөнгө	0.00	0.00
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	0.00	136,729,918.35
31210	Төгрөг	0.00	136,729,918.35
31211	Төрийн сангийн харилцах	0.00	136,729,918.35
33	АВЛАГА	0.00	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	77,176,895.29	80,623,308.15
35400	Хангамжийн материал	77,176,895.29	80,623,308.15
35410	Бичиг хэргийн материал	1,315,000.00	1,615,000.00
35420	Аж ахуйн материал	55,660,560.00	55,960,560.00
35430	Сэлбэг хэрэгсэл	3,500,000.00	3,500,000.00
35460	Хүнсний материал	111,491.97	315,659.98
35470	Бусад хангамжийн материал	16,589,843.32	19,232,088.17
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,583,740,656.11	1,586,044,548.37
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,583,740,656.11	1,586,044,548.37
39200	Биет хөрөнгө	1,565,492,656.11	1,567,796,548.37
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,440,491,894.78	1,440,491,894.78
39202	Хуримтлагдсан элэгдэл	-77,543,793.21	-113,501,739.57
39203	Авто-тээврийн хэрэгсэл	5,000,000.00	5,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	0	-1,666,666.68
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	154,992,108.43	201,782,108.43
39206	Хуримтлагдсан элэгдэл	-83,027,791.93	-117,756,977.36
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	66,921,300.44	70,446,300.44
39208	Хуримтлагдсан элэгдэл	-23,797,413.06	-30,373,696.29
39214	Бусад үндсэн хөрөнгө	102,384,204.92	139,384,204.92
39215	Хуримтлагдсан элэгдэл	-41,423,103.48	-51,062,686.32
39217	Ном	21,495,249.22	25,053,806.02
39300	Биет бус хөрөнгө	18,248,000.00	18,248,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	18,248,000.00	18,248,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,660,917,551.40	1,803,397,774.87
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,660,917,551.40	1,803,397,774.87
51	Засгийн газрын хувь оролцоо	1,660,917,551.40	1,803,397,774.87
51100	Засгийн газрын оруулсан капитал	1,660,917,551.40	439,352,988.00
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	439,352,988.00	0.00
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө		439,352,988.00
51200	Хуримтлагдсан үр дүн	-404,076,599.77	-261,596,376.30
51210	Өмнөх үеийн үр дүн	-913,994,401.72	-2,064,994,151.17
51220	Тайлант үеийн үр дүн	509,917,801.95	1,803,397,774.87
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,625,641,163.17	1,625,641,163.17
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,660,917,551.40	1,803,397,774.87

2.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,566,776,775.21	2,967,640,423.05
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	577,724,185.21	1,722,326,723.05
120	Нийтлэг татварын бус орлого	577,724,185.21	1,722,326,723.05
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.00	6,213,800.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,000,000.00	0.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	514,000.00	6,213,800.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	545,337,195.65	1,636,009,212.91
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	32,386,989.56	80,103,710.14
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	989,052,590.00	1,428,925,849.53
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	840,488,600.00	1,229,788,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0.00	1,229,788,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	35,000.00	15,525,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	35,000.00	15,525,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	140,014,990.00	183,612,149.53
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,034,268,347.57	1,164,242,648.18
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,034,268,347.57	1,164,242,648.18
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	994,265,475.37	1,074,543,650.73
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	668,495,267.00	830,127,748.00
210101	Үндсэн цалин	429,138,072.00	590,698,330.00
210102	Нэмэгдэл	199,959,352.00	204,687,733.00
210104	Урамшуулал	39,397,843.00	34,741,685.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	88,264,411.80	107,807,860.60
210201	Тэтгэврийн даатгал	61,594,773.01	73,906,962.11
210202	Тэтгэмжийн даатгал	6,735,301.99	9,031,207.70
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,388,222.24	6,930,590.59
210204	Ажилгүйдлийн даатгал	1,317,275.16	1,630,826.36
210205	Эрүүл мэндийн даатгал	13,228,839.40	16,308,273.84
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	139,569,390.00	148,608,567.53
210301	Гэрэл, цахилгаан	4,356,190.00	3,254,867.53
210302	Түлш, халаалт	116,596,000.00	126,736,500.00
210303	Цэвэр, бохир ус	18,617,200.00	18,617,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,087,746.00	0.00
210401	Бичиг хэрэг	756,900.00	0.00
210402	Тээвэр, шатахуун	1,200,000.00	0.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,069,500.00	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	431,100.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,630,246.00	0.00
2105	Нормативт зардал	8,410,897.03	16,856,981.59
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	233,400.00	0.00
210502	Хоол, хүнс	7,337,857.03	16,856,981.59
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	839,640.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,466,900.00	12,000,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	470,000.00	0.00
210604	Урсгал засвар	1,996,900.00	12,445,600.00

Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2107	Томилолт, зочны зардал	585,400.00	0.00
210702	Дотоод албан томилолт	585,400.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,700,000.00	6,868,150.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,692,000.00	3,643,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,008,000.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	3,225,150.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	75,685,463.54	135,440,892.54
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	33,895,158.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,763,400.00	12,976,070.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	72,922,063.54	88,569,664.54
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	40,002,872.20	89,698,997.45
2132	Бусад урсгал шилжүүлэг	29,487,298.00	89,698,997.45
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	28,987,298.00	66,188,827.45
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	23,510,170.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	10,515,574.20	0.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,515,574.20	0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	532,508,427.64	1,803,397,774.87
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0.00	0.00
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	0.00
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	22,590,626.69	0.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	509,917,801.95	1,803,397,774.87

2.3 Аудит хийсэн МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/ төгрөгөөр /			
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	989,052,590.00	1,435,139,649.53
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,514,000.00	6,213,800.00
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	6,213,800.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	8,514,000.00	6,213,800.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,000,000.00	0.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	514,000.00	6,213,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	840,523,600.00	1,245,313,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	840,488,600.00	1,229,788,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	840,488,600.00	1,229,788,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	35,000.00	15,525,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	35,000.00	15,525,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	140,014,990.00	183,612,149.53
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	140,014,990.00	183,612,149.53
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	965,418,390.00	1,076,192,581.65
21	УРСГАЛ ЗАРДАЛ	965,418,390.00	1,076,192,581.65
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	925,325,317.80	986,362,664.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	668,495,267.00	799,517,209.00
210101	Үндсэн цалин	429,138,072.00	830,127,748.00
210102	Нэмэгдэл	199,959,352.00	590,698,330.00
210104	Урамшуулал	39,397,843.00	204,687,733.00
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	34,741,685.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	88,264,411.80	107,807,860.60
210201	Тэтгэврийн даатгал	61,594,773.01	73,906,962.11
210202	Тэтгэмжийн даатгал	6,735,301.99	9,031,207.70
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,388,222.24	6,930,590.59
210204	Ажилгүйдлийн даатгал	1,319,838.23	1,630,826.36
210205	Эрүүл мэндийн даатгал	13,226,276.33	16,308,273.84
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	139,569,390.00	148,608,567.53
210301	Гэрэл, цахилгаан	4,356,190.00	3,254,867.53
210302	Түлш, халаалт	116,596,000.00	126,736,500.00
210303	Цэвэр, бохир ус	18,617,200.00	18,617,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,754,200.00	0.00
210401	Бичиг хэрэг	756,900.00	0.00
210402	Тээвэр, шатахуун	1,200,000.00	0.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,069,500.00	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	431,100.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,296,700.00	0.00
2105	Нормативт зардал	11,760,349.00	28,581,829.60
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	233,400.00	0.00
210502	Хоол, хүнс	7,359,149.00	28,581,829.60
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,167,800.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,466,900.00	12,445,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	470,000.00	0.00
210602	Тавилга	1,996,900.00	0.00
210604	Урсгал засвар	0.00	12,445,600.00
2107	Томилолт, зочны зардал	585,400.00	0.00

**Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210702	Дотоод албан томилолт	585,400.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,666,000.00	6,810,550.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,658,000.00	3,585,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,008,000.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	3,225,150.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,763,400.00	47,244,258.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	34,552,758.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,763,400.00	12,691,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	78,178,317.45
2132	Бусад урсгал шилжүүлэг	29,577,498.00	78,178,317.45
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	29,077,498.00	4,668,147.45
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	23,510,170.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	10,515,574.20	0.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,515,574.20	0.00
213504	Хөрөнгийн	0.00	0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	0.00	175,334,918.35
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	0.00	0.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	0.00	38,605,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	38,605,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	23,634,200.00	38,605,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	23,634,200.00	38,605,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-23,634,200.00	-38,605,000.00
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0.00	0.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0.00	136,729,918.35
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	136,729,918.35

2.4 Аудит хийсэн ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /					
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	439,352,988.00	1,625,641,163.17	-913,994,401.72	1,150,999,749.45
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	439,352,988.00	1,625,641,163.17	-913,994,401.72	1,150,999,749.45
7	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	509,917,801.95	509,917,801.95
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	439,352,988.00	1,625,641,163.17	-404,076,599.77	1,660,917,551.40
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	439,352,988.00	1,625,641,163.17	-2,064,994,151.17	0.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	439,352,988.00	1,625,641,163.17	-2,064,994,151.17	0.00
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
17	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	1,803,397,774.87	1,803,397,774.87
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	439,352,988.00	1,625,641,163.17	-261,596,376.30	1,803,397,774.87

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	гүйцэтгэл	харьцуулалт
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,435,139,649.53	1,298,409,731.18	136,729,918.35	90.47
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,435,139,649.53	1,298,409,731.18	136,729,918.35	90.47
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,435,139,649.53	1,298,409,731.18	136,729,918.35	90.47
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	927,350,139.00	830,127,748.00	97,222,391.00	89.52
210101	Үндсэн цалин	691,446,434.00	590,698,330.00	100,748,104.00	85.43
210102	Нэмэгдэл	204,077,105.00	204,687,733.00	-610,628.00	100.30
210104	Урамшуулал	31,826,600.00	34,741,685.00	-2,915,085.00	109.16
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	116,039,843.00	107,807,860.60	8,231,982.40	92.91
210201	Тэтгэврийн даатгал	78,907,062.48	73,906,962.11	5,000,100.37	93.66
210202	Тэтгэмжийн даатгал	9,283,195.13	9,031,207.70	251,987.43	97.29
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,426,536.11	6,930,590.59	495,945.52	93.32
210204	Ажилгүйдлийн даатгал	1,856,659.02	1,630,826.36	225,832.66	87.84
210205	Эрүүл мэндийн даатгал	18,566,390.26	16,308,273.84	2,258,116.42	87.84
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	148,608,567.53	148,608,567.53	0.00	100.00
210301	Гэрэл, цахилгаан	3,254,867.53	3,254,867.53	0.00	100.00
210302	Түлш, халаалт	126,736,500.00	126,736,500.00	0.00	100.00
210303	Цэвэр, бохир ус	18,617,200.00	18,617,200.00	0.00	100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	0.00	0.00	
2105	Нормативт зардал	17,823,000.00	16,930,229.60	892,770.40	94.99
210502	Хоол, хүнс	17,823,000.00	16,930,229.60	892,770.40	94.99
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,970,600.00	15,970,600.00	0.00	100.00
	Тавилга	3,525,000.00	3,525,000.00	0.00	100.00
210604	Урсгал засвар	12,445,600.00	12,445,600.00	0.00	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,740,400.00	6,810,550.00	5,929,850.00	53.46
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,695,800.00	3,585,400.00	110,400.00	97.01
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	9,044,600.00	3,225,150.00	5,819,450.00	35.66
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	90,668,400.00	82,324,258.00	8,344,142.00	90.80
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	77,101,400.00	69,632,758.00	7,468,642.00	90.31
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,567,000.00	12,691,500.00	875,500.00	93.55
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	105,938,700.00	89,829,917.45	16,108,782.55	84.79
2132	Бусад урсгал шилжүүлэг	105,938,700.00	89,829,917.45	16,108,782.55	84.79
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	82,422,700.00	66,319,747.45	16,102,952.55	80.46
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	23,516,000.00	23,510,170.00	5,830.00	99.98
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	0.00	0.00	

III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,435,139,649.53	1,435,139,649.53	0.00	100.00
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,229,788,700.00	1,229,788,700.00	0.00	100.00
310001	Улсын төсвөөс санхүүжих	1,229,788,700.00	1,229,788,700.00	0.00	100.00
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	183,612,149.53	183,612,149.53	0.00	100.00
320001	Орон нутгийн төсвөөс	183,612,149.53	183,612,149.53	0.00	100.00
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	21,738,800.00	21,738,800.00	0.00	100.00
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15,525,000.00	15,525,000.00	0.00	100.00
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,213,800.00	6,213,800.00	0.00	100.00
37	БУСАД ЭХ ҮҮСВЭР	0.00	0.00	0.00	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00	0.00	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	136,729,918.35	136,729,918.35	
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	0.00	0.00	0.00	
620001	Удирдах ажилтан	0.00	0.00	0.00	
620002	Гүйцэтгэх ажилтан	0.00	0.00	0.00	
620003	Үйлчлэх ажилтан	0.00	0.00	0.00	
620004	Гэрээт ажилтан	0.00	0.00	0.00	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1. БАЙГУУЛЛАГА, ТҮҮНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хүдэр сумын ерөнхий боловсролын сургууль нь “Хүүхэд бүрийн сурч төлөвших нөхцөлийг бүрлүүлж, багш бүрийг хөгжүүлэхэд хамтран ажиллая” гэсэн зорилго тавин ажиллаж байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Бага суурь бүрэн дунд боловсролын цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэх суралцагч бүрийн сурлагын чанарыг ахиулахын тулд суралцагчдыг оношлох, явцын болон үр дүнгийн, хөндлөнгийн үнэлгээг хийж үр дүнг тооцон ажиллах
- Багш бүр мэдлэг боловсролоо дээшлүүлэн багшийн ёс зүйг эрхэмлэн ажиллах

3.2. Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн байна.
- Төрийн хэмнэлтийн тухай тухай хууль хэрэгжиж эхэлсэн,
- Төрийн албаны тухай хуульд 2022 оны 04 дүгээр сарын 22, 07 дугаар сарын 05, 11 дугаар сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон.
- Боловсролын тухай хуульд 2022 онд 3 удаа нэмэлт өөрчлөлт орсон,
- ЗГ-ын 2022 оны 91 дүгээр тогтоолоор батлагдсан “Хувьсах зардлын дундаж норматив, аргачлал батлах тухай” журам хэрэгжиж эхэлсэн,
- ЗГ-ын 2019 оны 472 дугаар тогтоолын 5, 6 дугаар хавсралтаар батлагдсан “Шинжлэх ухааны байгууллага, сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн сүлжээ батлах тухай ” тогтоолд 2022 оны 107 дугаар тогтоолоор батлагдсан “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай” тогтоол, 2022 оны 192 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан,
- ЗГ-ын 2019 оны 5 дугаар тогтоолын гуравдугаар хавсралтаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багш, туслах багш, албан хаагчид олгох улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох” тогтоолд 2022 оны 252 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан,
- БШУС-ын 2022 оны А/170 дугаар тушаалаар батлагдсан “Хичээл, сургалтын үйл ажиллагааны зардлыг төлөвлөх, хуваарилах заавар”-ыг хэрэгжүүлж эхэлсэн,

- БШУС-ын 2022 оны А/465 дугаар тушаалаар батлагдсан “Ерөнхий боловсролын сургуульд, кабинет, лаборатори, цахим сургалтын танхим байгуулах, ашиглах нийтлэг журам”-ыг шинэчлэн баталсан,
- ХНХС-ын 2021 оны А/192 дугаар тушаалаар батлагдсан “Дундаж цалин хөлс тодорхойлох журам” хэрэгжиж эхэлсэн.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагч болох БШУЯ-ны зүгээс дотоод аудит, хяналт, шалгалт хийгдээгүй бөгөөд дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хүдэр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Тус байгууллага нь өмнөх онуудад тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүждэг байсны хувьд Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2020 оны А/202 тоот захирамжаар баталсан Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн харьяа төсөвт байгууллагууд дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг тайлант онд мөрдөж ирсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй өөрөөр хэлбэл боловсролын салбарын онцлогт тохирохгүй байна.

3.4. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хүдэр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 142,480.3 мянган төгрөгөөр буюу 92.0 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө		136,730.00	136,730.00
Бараа материал	77,176.90	80,623.30	3,446.40
Үндсэн хөрөнгө	1,583,740.60	1,586,044.50	2,303.90
Нийт хөрөнгө	1,660,917.50	1,803,397.80	142,480.30
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,660,917.50	1,803,397.80	142,480.30
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,660,917.50	1,803,397.80	142,480.30

Тайлант жилийн үйл ажиллагааны зардлын хэмнэлт 136,730.0 мянган төгрөгийг Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралт “Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх аргачлал”-ын 8.7-д “Боловсролын сургалтын байгууллагын жилийн эцсийн дансны үлдэгдлийг дараагийн төсвийн жилд шилжүүлнэ” гэж заасны дагуу төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнагдсан байна.

Бараа материал дансны үлдэгдэл 3,446.4 мянган төгрөгөөр өссөн нь аймгийн БШУГ-аас 2,926.8 мянган төгрөгийн ном үнэ төлбөргүйгээр хүлээн авсан, төсвийн хөрөнгөөр 130,935.0 мянган төгрөгийн бараа материал бэлтгэн, 130,415.4 мянган төгрөгийн бараа материал зарцуулснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 90,873.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь БШУЯ-наас 11,960.0 мянган төгрөгийн гал тогооны тоног төхөөрөмж, аймгийн БШУГ-аас 3,308.6 мянган төгрөгийн ном, төгсөгчдийн хандиваар 37,000.0 мянган төгрөгөөр гадна талбайг зассаныг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан, төсвийн хөрөнгөөр 38,605.0 мянган төгрөгийн таблет, тавилга эд хогшил худалдан авснаас шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,803,397.8 мянган төгрөг болж 142,480.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн өссөнөөс шалтгаалсан байна.

3.5. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд

захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус сургуулийн 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,146,651.1 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 183,612.1 мянган төгрөгөөр, нийт зарлагыг **1,330,263.2** мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

2022 оны 11 дүгээр сард хийсэн төсвийн зохицуулалтаар хүүхдэд ээлтэй орчны зардалд 26,225.5 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 26,970.0 мянган төгрөг, үдийн цайны зардалд 6,500.0 мянган төгрөгөөр нийт 59,695.5 мянган төгрөгөөр төсвийг нэмж, улсын төсвөөс 1,229,788.7 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 183,612.1 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 15,525.0 мянган төгрөг, төслийн санхүүжилт 2,518.0 мянган төгрөг, түрээсийн номын орлого 3,695.8 мянган төгрөг буюу нийт **1,435,139.6** мянган төгрөгийн эх үүсвэрийг баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 13 арга хэмжээг санхүүжүүлэхээр **1,435,139.6** мянган төгрөгийн төсөв баталснаас 1,229,788.7 мянган төгрөгийг улсын төсвөөс, 183,612.1 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 21,738.8 мянган төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос урсгал үйл ажиллагаанд захиран зарцуулахаар төлөвлөгдсөн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **1,298,409.6** мянган төгрөг буюу 90.5 хувьтай тайлагнагдсан нь цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардлыг 105,454.3 мянган төгрөгөөр, төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшууллын зардал 16,108.8 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 8,344.1 мянган төгрөгөөр, мэдээлэл технологийн үйлчилгээний зардал 5,819.4 мянган төгрөгөөр, хоол, хүнсний зардал 892.8 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр	д/д	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
						зөрүү	Биелэлт
1	71802 Ерөнхий боловсрол	1	80226- Байр ашиглалтын үйлчилгээ	3,617.90	2,927.70	690.20	0.8
		2	80312- Сургалт семинар	1,808.90	1,720.00	88.90	1.0
		3	81605- Эрүүл мэндийг дэмжих	4,160.50	3,780.40	380.10	0.9
		4	81801- Үдийн цай хөтөлбөр	82,422.70	66,319.70	16,103.00	0.8
		5	81806- Дотуур байрны үйлчилгээ	34,148.10	30,653.70	3,494.40	0.9
		6	81816- Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	37,465.00	34,830.00	2,635.00	0.9
		7	81823- Боловсролын багшийн сургалт	8,140.20	4,408.20	3,732.00	0.5

	8	81834-Боловсролын стандарт сургалт	913,645.20	825,654.30	87,990.90	0.9
	9	81835- Сургалтын хэвийн үйл ажиллагаа	144,380.20	122,817.50	21,562.70	0.9
	10	81848-Сурах бичгийн түрээс	3,695.80	3,643.00	52.80	1.0
	11	83602- Дээд шатны төсвөөс	2,518.00	2,518.00	0.00	1.0
	12	80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	183,612.10	183,612.10	0.00	1.0
	13	80112-Нийтлэг үйлчилгээ	15,525.00	15,525.00	0.00	1.0
	Нийт		1,435,139.60	1,298,409.60	136,730.00	90.5

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв:

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус сургуулийн нэмэлт санхүүжилтийн дансанд орлого, зарлагын гүйлгээ хийгдээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын ерөнхий боловсролын сургуулийн /цаашид Хүдэр сумын ерөнхий боловсролын сургууль гэх/ 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Бэйкер Тилли Далайван аудит” ХХК-ийн Дархан салбарын аудитор Л.Дамдинжав, аудиторын туслах Б.Сувд-Эрдэнэ нар гүйцэтгэж, хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Хүдэр сумын ерөнхий боловсролын сургууль нь 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Бэйкер Тилли Далайван аудит” ХХК-ийн Дархан салбар-т 2023 оны 01 дүгээр сарын 25-ний өдрийн 07 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2. Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,034,268.3 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 10,342.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Боловсролын ерөнхий газраас нийт боловсролын байгууллагуудад 2022 оны 04, 09 дүгээр саруудад Төрийн хэмнэлтийн тухай хууль болон ЗГ-ын 2022 оны 203 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, төсвийн хэмнэлтийн горимоор ажиллах, орон тоог хязгаарлах, төрийн үйл ажиллагааг цахимжуулах, бараа үйлчилгээний зардлыг бууруулах, зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Хүдэр сумын ерөнхий боловсролын сургууль нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг дараах байдлаар хэрэгжүүлжээ. Үүнд:

- Тайлант онд төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшууллын зардал, дотуур байрны хоолны зардал, бараа үйлчилгээний бусад зардал, орон дутуу ажилласнаас цалин, ажил олгогчоос төлөх НДШ-н зардлаас нийт 136,730.0 мянган төгрөгийн хэмнэлтийг бий болгосон байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Хүдэр сумын ерөнхий боловсролын сургууль нь мэдээлбэл зохих 20 төрлийн 151 мэдээллээс 8 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг бүрэн байршуулах, зөрчлийг давтан гаргахгүй ажиллах талаар зөвлөмж өгөгдсөн боловч бүрэн хэрэгжүүлээгүйгээс тайлант хугацаанд мэдээлбэл зохих 20 төрлийн 151 мэдээлэл байршуулахаас 8 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн. Үүнд:

- Төсөв гүйцэтгэлтэй холбоотой мэдээллийг 2 удаа хугацаа хоцроож, мэдээлсэн,
- Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалттай холбоотой мэдээллийг 5 удаа хугацаа хоцроож мэдээлсэн,
- Бусад мэдээллийг 1 удаа хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн холбогдох заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгсөн холбогдох хууль, тогтоомжийн дагуу шилэн дансны тухай хуулийн дагуу холбогдох мэдээллийг тогтоосон хугацаанд мэдээлж байх гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу **албан шаардлага** хүргүүлэхээр шийдвэрлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

“Бэйкер Тилли Далайван аудит” ХХК-ийн Дархан салбарын 2022 оны 11 дүгээр 09-ны өдрийн 46 дугаар албан бичгээр “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” захидлыг хүргүүлсэн бөгөөд тус сургуулийн 2022 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар цалин хөлстэй холбоотой 154.1 мянган төгрөгийн алдаа зөрчилд акт тогтоож, төлбөрийн цахим баримттай холбоотой 38,446.2 мянган төгрөгийн зөрчлийг арилгах зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	154.1	1	154.1	100.00
Албан шаардлага					
Зөвлөмж	2	38,446.2	2	38,446.2	100.0
Нийт дүн	3	38,600.3	3	38,600.3	100.00

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараах асуудлууд нь тухайн төсвийн захирагчийн бус дээд шатны төсвийн захирагчийн шийдвэрээр хэрэгжсэн учир дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

1. Дээд шатны төсөв захирагчаас төсвийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна. Иймд төсвийг бодит гүйцэтгэлтэй нь уялдуулан зардлын бүлэг, зүйл бүрээр төлөвлөж, зарцуулан, хяналт тавьж байх шаардлагатай байна.
2. Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хааж нэмэлт санхүүжилттэй холбоотой гүйлгээг урсгал дансаар дамжуулан “Нэмэлт - Дээд шатны төсвөөс хуваарилсан” гэсэн зориулалтаар, төсөвт байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлого /120010/ ангиллаар гүйцэтгэхээр чиглэл хүргүүлсэн байна. Нэмэлтээр хуваарилах төсвийн эх үүсвэрийг төсвийн санхүүжилтийн эх үүсвэр болгон төлөвлөж байгаагаас гүйцэтгэлээр уг санхүүжилт хуваарилагдаагүй тохиолдолд төсвийн санхүүжилтийн төлөвлөгөө тасарснаар тайлагнагдах эрсдэлтэй байна. Иймд дээд шатны төсвөөс хуваарилах нэмэлт төсвийг төсвийн санхүүжилт хэлбэрээр урьдчилан төлөвлөж, батлалгүйгээр санхүүжилт ирсэн тухай бүр тухайн санхүүжилтийн дүнгээр зарцуулах эрх тавих нь зүйтэй юм.
3. Тус байгууллага нь өмнөх жилүүдэд тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүждэг байсан учир Сэлэнгэ аймгийн ЗД-ын 2020 оны 7 дугаар сарын 16-ний өдрийн А/202 дугаар захирамжаар баталсан “Сэлэнгэ аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад хамаарах төсөвт байгууллагуудад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг мөрдөж ирсэн байна. Бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох

бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч боловсролын байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирохгүй учир төсвийн ерөнхийлөн захирагчийн боловсруулсан НБББББ-ыг мөрдөх нь зүйтэй юм.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт **7,924.6** мянган төгрөгийн зөрчил илэрч 1,092.7 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 6,831.9 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

1. Сургалтын менежер Б.Цэрэндулам, багш Г.Тодбаяр, Ц.Отгонбаяр нарын цалингийн нэмэгдлүүдийг 2 дахин бодож 1,092.7 мянган төгрөгийн цалин илүү олгосон нь нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно*”, 20.2.5 дахь “*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалингийн нэмэгдлүүдийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

5.2 Зөвлөмж

1. Санхүүгийн тайлантай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Нийгмийн даатгалын тайланд багш нарын амралтын цалинг 6,831.9 мянган төгрөгөөр илүү тооцож тайлагнасан нь “Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1-д “*хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх*” гэсэн заалттай нийцэхгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Илүү тайлагнасан цалинг 2023 оны 1 дүгээр улиралд залруулга хийж зөв дүнгээр тайлагнах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс													
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал					
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Илүү цалин олгосон	1	1,092.7	1	1,092.7												
НД тайланд цалин илүү тайлагнасан	1	6,831.9					1	6,831.9								
Дүн	2	7,924.6	1	1,092.7			1	6,831.9								

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж					
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил												
Шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроосон	8				8							
Огт мэдээлээгүй												
Дүн	8				8							
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил												
Дүн												
Нийт дүн												